



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ДАРГА ДАШЗЭГВИЙН  
АМАРБАЯСГАЛАН ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,  
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201  
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,  
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,  
Цахим худас: www.mongolia.gov.mn

2024.12.23 № 3г-1/165  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх тухай

Европын сэргээн босголт, хөгжлийн банк үүсгэн байгуулах тухай хэлэлцээрт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрч, соёрхон батлах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 77.1-д заасны дагуу зөвшилцэх, хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгөхийг хүсье.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ





## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,  
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201  
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,  
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,  
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2024. 11. 21 № Хэг/2300  
таний -ны № -т

Г Хуулийн төсөл өргөн мэдүүлэх  
хугацааг товлох тухай

Европын сэргээн босголт, хөгжлийн банк үүсгэн байгуулах тухай хэлэлцээрт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрч, соёрхон батлах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 77.1-д заасны дагуу Улсын Их Хуралд хүргүүлэхээр шийдвэрлэснийг холбогдох материалын хамт хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлож өгөхийг хүсье.

Хавсралт<sup>30</sup> хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



Н.УЧРАЛ



МОНГОЛ УЛСЫН  
ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД

Энхтайваны өргөн чөлөө 7а,  
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14210  
Утас: 26 21 35, Факс: (976-11) 32 21 27,  
Цахим шуудан: info@mfa.gov.mn,  
Цахим хуудас: www.mfa.gov.mn

2024 - II - 13 № 09 / 5453  
таний -ны № 01 / 9099 -т

САНГИЙН САЙД Б.ЖАВХЛАН ТАНАА

Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.9-д заасны дагуу Европын сэргээн босголт, хөгжлийн банк үүсгэн байгуулах тухай хэлэлцээрт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрч, соёрхон батлах тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрлийг үүгээр олгов.

  
*М.Батцэцэг* Б.БАТЦЭЦЭГ

1142402653



## МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,  
4-р хороо, Чингэлтэй дүүргэ, 15160 Улаанбаатар хот,  
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,  
Цахим хуудас: http://www.mof.gov.mn

2024. 11. 13 № 0119381

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Н.УЧРАЛ ТАНАА

Европын сэргээн босголт, хөгжлийн банк  
үүсгэн байгуулах тухай хэлэлцээрт оруулсан  
нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрч, соёрхон  
батлах тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн  
тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт  
заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг  
зөвшөөрөв.

Хавсралт: ... хуудастай.

Хүндэтгэсэн,



9761002378



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,  
ДОТООД ХЭРГИЙН САЙД

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас/Факс: (976-51) 26 75 33,  
Цахим шуудан: info@mojha.gov.mn,  
Цахим хуудас: www.mojha.gov.mn

2024.11.11 № 1/1717  
таний -ны № 119100-т

САНГИЙН САЙД Б.ЖАВХЛАН  
ТАНАА

Европын сэргээн босголт, хөгжлийн банк  
үүсгэн байгуулах тухай хэлэлцээрт оруулсан нэмэлт,  
өөрчлөлтийг хүлээн зөвшөөрч, соёрхон батлах тухай  
хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20  
дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасны дагуу Улсын  
Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.



A5.файл.2024

**МОНГОЛ УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ  
ТЭМДЭГЛЭЛЭС**

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн хуралдааны 38 дугаар тэмдэглэлд:

**“4.ХЭЛЭЛЦСЭН нь:** Европын сэргээн босголт, хөгжлийн банк үүсгэн байгуулах тухай хэлэлцээрт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрч, соёрхон батлах тухай хуулийн төсөл

**ШИЙДВЭРЛЭСЭН нь:** Европын сэргээн босголт, хөгжлийн банк үүсгэн байгуулах тухай хэлэлцээрт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрч, соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 77.1-д заасны дагуу зөвшилцөх, хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд хүргүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



**ХЭЛЭЛЦЭЭРТ ОРУУЛСАН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРЧ,  
СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

**Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага**

Европын сэргээн босголт, хөгжлийн банк (ЕСБХБ) үүсгэн байгуулах тухай хэлэлцээр нь тус банкны Захирагч нарын зөвлөлөөр хэлэлцэгдэн 2023 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн 259 болон 260 дугаар тогтоол батлагдаж тус хэлэлцээрийн 1 дүгээр зүйл болон 12.1 дүгээр зүйлүүдэд холбогдох өөрчлөлт оруулахаар шийдвэрлэсэн. Энэхүү хэлэлцээрт оруулсан өөрчлөлтүүд нь ЕСБХБ-ны дотоод засаглал, үйл ажиллагааны хүрээнд төвлөрч байгаа учир Монгол Улсад сөрөг нөлөө үзүүлэхгүй бөгөөд харин тус банкны үйл ажиллагааг төрөлжүүлж, банкны тогтвортой байдал болон гишүүн орнуудад үзүүлэх дэмжлэгийг сайжруулна гэж үзэж байна. Түүнчлэн, хэлэлцээрт оруулсан өөрчлөлтүүд нь олон улсын санхүүгийн байгууллагуудын өмнө Монгол Улсын үүрэг хариуцлагыг бататгаж, ил тод байдал, хариуцлагын зарчмыг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулах бөгөөд энэ нь хөрөнгө оруулагчдад илүү итгэл төрүүлж, хууль зүйн орчныг тогтвортой, найдвартай байлгах нөхцөлийг бүрдүүлнэ.

Монгол Улсын Их Хурал 2000 онд Европын сэргээн босголт, хөгжлийн банк үүсгэн байгуулах тухай хэлэлцээрийг хүлээн зөвшөөрч, нэгдэн орсныг соёрхон баталсан бөгөөд үүний дараагаар 2013 онд ЕСБХБ Өмнөд болон Зүүн Газар дундын тэнгисийн бүс нутагт үйл ажиллагаагаа тэлэх зорилгоор ЕСБХБ үүсгэн байгуулах тухай хэлэлцээртээ өөрчлөлт оруулсныг мөн соёрхон баталж байсан болно.

Иймд Монгол Улсын Олон улсын гэрээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт заасны дагуу тус хэлэлцээрт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг Улсын Их Хурлаар соёрхон батлуулах шаардлагатай тул хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсрууллаа.

**Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа,  
хамрах хүрээ**

Хуулийн төсөл нь 2 зүйтэй байх ба 1 дүгээр зүйлд Европын сэргээн босголт, хөгжлийн банк үүсгэн байгуулах хэлэлцээрт оруулсан нэмэлт,

өөрчлөлтийг хүлээн зөвшөөрч, соёрхон батлахыг, 2 дугаар зүйлд хууль хүчин төгөлдөр болох хугацааг тусгасан болно.

**Гурав.Хуулийг хэрэгжүүлснээр гарч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар**

Хуулийг баталснаар нийгэм, эдийн засаг, хууль зүйн сөрөг үр дагавар гарагчгүй.

**Дөрөв.Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, шинэчлэн найруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн тухай**

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хууль тогтоомжтой нийцсэн байх бөгөөд уг хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, шинэчлэн найруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл шаардлагагүй болно.

---00---

## **Товч танилцуулга**

Хэлэлцээрт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрч, соёрхон батлах тухай хуулийн төслийн талаар

### **1. Ерөнхий агуулга, зохицуулах харилцаа, зарчмын шинжтэй зохицуулалт:**

Уг хуулийн төсөл нь 2 зүйлтэй бөгөөд 1 дүгээр зүйлд Энэхүү Европын сэргээн босголт, хөгжлийн банк үүсгэн байгуулах тухай хэлэлцээрт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрч, соёрхон батлахыг, 2 дугаар зүйлд хууль хүчин төгөлдөр болох хугацааг тусгасан болно.

Энэхүү Европын сэргээн босголт, хөгжлийн банк үүсгэн байгуулах тухай хэлэлцээрт оруулсан нэмэлт, өөрчлөлт нь Олон улсын гэрээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт заасны дагуу Улсын Их Хурал соёрхон батлах хуулийн зохицуулалттай болно.

### **2. Тухайн харилцааг урьд нь хууль, эрх зүйн бусад актаар зохицуулж ирсэн байдал:**

Монгол Улсын Их Хурал 2000 онд Европын сэргээн босголт, хөгжлийн банк үүсгэн байгуулах тухай хэлэлцээрийг хүлээн зөвшөөрч, нэгдэн орсныг соёрхон баталсан бөгөөд үүний дараагаар 2013 онд Европын сэргээн босголт, хөгжлийн банк Өмнөд болон Зүүн Газар дундын тэнгисийн бүс нутагт үйл ажиллагаагаа тэлэх зорилгоор Европын сэргээн босголт, хөгжлийн банк үүсгэн байгуулах тухай хэлэлцээртээ оруулсан нэмэлт, өөрчлөлтийг мөн хүлээн зөвшөөрч, соёрхон баталж байсан болно.

### **3. Хуулийн төслийг боловсруулахтай холбогдуулан хууль санаачлагчаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:**

Европын сэргээн босголт, хөгжлийн банк байгуулах тухай хэлэлцээрт оруулсан нэмэлт, өөрчлөлтийн агуулга, зохицуулалтын хүрээг судалж, Монгол Улсад үзүүлэх нөлөөллийг дүгнэсэн.

### **4. Гадаад орны туршлага, бусад судалгаа, шинжилгээний тайлангийн дүгнэлт:**

Европын сэргээн босголт, хөгжлийн банкны гаргасан банкны үйл ажиллагааны тайлан болон гишүүн орнуудын саналуудыг үндэслэн тус банкны зүгээс Сахарын цөлийн өмнөд болон түүнээс урагш орших Африкийн бүс нутагт үйл ажиллагаагаа өргөжүүлэх нь тус банкны олон улсын дэмжлэгийг сайжруулж, гишүүн орнуудад санхүүжилтийн шинэ эх үүсвэр нээх чухал ач холбогдолтой гэж үзэж байгаа болно.

## **Дэлгэрэнгүй танилцуулга**

**Хэлэлцээрт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрч,  
соёрхон батлах тухай хуулийн төслийн талаар**

### **Зохицуулахаар тусгасан харилцааны агуулга, зохицуулалтыг хэрхэн ойлгох тухай:**

Уг хуулийн төсөл нь 2 зүйтэй бөгөөд 1 дүгээр зүйлд Энэхүү Европын сэргээн босголт, хөгжлийн банк үүсгэн байгуулах тухай хэлэлцээрт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрч, соёрхон батлахыг, 2 дугаар зүйлд хууль хүчин төгөлдөр болох хугацааг тусгасан болно.

Энэхүү Европын сэргээн босголт, хөгжлийн банк үүсгэн байгуулах тухай хэлэлцээрт оруулсан нэмэлт, өөрчлөлт нь Олон улсын гэрээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт заасны дагуу Улсын Их Хурал соёрхон батлах хуулийн зохицуулалттай болно.

### **Европын сэргээн босголт, хөгжлийн банк үүсгэн байгуулах тухай хэлэлцээрт оруулсан нэмэлт, өөрчлөлтийн тухай**

Монгол Улс нь 2000 оны 7 дугаар сарын 26-ны өдөр Европын сэргээн босголт, хөгжлийн банк (цаашид “ЕСБХБ” гэх)-ыг үүсгэн байгуулах тухай хэлэлцээрийг хүлээн зөвшөөрч, Монгол Улсын Их Хурал соёрхон баталснаар тус банкны 61 дэх гишүүнээр элсэн орсон.

ЕСБХБ-ны Захирагч нарын зөвлөлөөс 2023 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн 259 болон 260 дугаар тогтоолыг баталж, ЕСБХБ үүсгэн байгуулах тухай хэлэлцээрийн 1 дүгээр зүйл болон 12.1 дүгээр зүйлүүдэд өөрчлөлт оруулахаар шийдвэрлэсэн.

Тус хэлэлцээрийн 1 дүгээр зүйлд оруулсан өөрчлөлтөөр ЕСБХБ-ны санхүүжилтийн үйл ажиллагаа нь Төв болон Зүүн Европ, Өмнөд болон Зүүн Газар дундын тэнгисийн бүс нутаг болон Монгол зэрэг орнуудыг хамарч байсныг өргөжүүлж, Сахарын цөлийн өмнөд болон түүнээс урагш орших Африкийн бүс нутгийн орнуудад үйл ажиллагаагаа явуулах боломж бүрдэж байгаа бол хэлэлцээрийн 12.1 дүгээр зүйлд оруулсан өөрчлөлт нь тус банкны санхүүгийн тогтвортой байдлыг хамгаалахын тулд ЕСБХБ-ны Захирлуудын зөвлөлд хөрөнгийн зохистой харьцааны хэмжүүрүүдтэй холбоотой тохирох хязгаарлалтыг тогтоон хадгалах эрхийг олгож байгаа болно.

Энэхүү хэлэлцээрт оруулсан нэмэлт, өөрчлөлт нь ЕСБХБ-ны дотоод засаглал, үйл ажиллагааны хүрээнд төвлөрч байгаа учир Монгол Улсад сөрөг нөлөө үзүүлэхгүй бөгөөд харин тус банкны үйл ажиллагааг төрөлжүүлж, банкны тогтвортой байдал болон гишүүн орнуудад үзүүлэх дэмжлэгийг сайжруулна гэж үзэж байна.

Монгол Улсын Их Хурал 2000 онд Европын сэргээн босголт, хөгжлийн банк үүсгэн байгуулах тухай хэлэлцээрийг хүлээн зөвшөөрч, нэгдэн орсныг соёрхон баталсан бөгөөд үүний дараагаар 2013 онд ЕСБХБ Өмнөд болон Зүүн Газар дундын тэнгисийн бүс нутагт үйл ажиллагаагаа тэлэх зорилгоор ЕСБХБ үүсгэн байгуулах тухай хэлэлцээртээ оруулсан нэмэлт, өөрчлөлтийг мөн хүлээн зөвшөөрч, соёрхон баталж байсан болно.

Олон улсын гэрээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт заасны дагуу тус хэлэлцээрт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрч, соёрхон батлах хуулийн төслийг Улсын Их Хурлаар хэлэлцүүлэх бөгөөд Монгол Улс хэлэлцээрт нэгдсэн орсон бүрэн эрхт гишүүний хувьд шийдвэрийг банканд албан ёсоор мэдэгдэх үүрэгтэй.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Төрийн ордон,  
Улаанбаатар хот

### ХЭЛЭЛЦЭЭРТ ОРУУЛСАН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРЧ, СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Европын сэргээн босголт, хөгжлийн банк үүсгэн байгуулах тухай хэлэлцээрт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрч, Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2024 оны ... дугаар сарын ... –ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## **ЕВРОПЫН СЭРГЭЭН БОСГОЛТ, ХӨГЖЛИЙН БАНК ҮҮСГЭН БАЙГУУЛАХ ТУХАЙ ХЭЛЭЛЦЭЭРТ ОРУУЛАХ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ**

**1 дүгээр зүйл**


### **ЗОРИЛГО**

Банкны зорилго нь олон намын тогтолцоо бүхий ардчилал, олон ургалч үзэл, зах зээлийн эдийн засгийн зарчмуудыг баримталж, амьдралд хэрэгжүүлж буй Төв болон Зүүн Европын орнуудын эдийн засагт хөгжил дэвшил гаргах, сэргээн босгох үйл хэрэгт хувь нэмрээ оруулж, тэдгээрийн зах зээлийн баримжаат нээлттэй эдийн засагт шилжих түүнчлэн хувийн болон аж ахуйн үйл ажиллагааны санаачлагыг дэмжин хөгжүүлэхэд туслахад оршино. Банкны зорилгыг түүнчлэн ижил төстэй нөхцөлөөр (i) Монгол Улс; (ii) Газрын дундад тэнгисийн Өмнөд болон Зүүн бүсийн гишүүн орнууд; ба (iii) Сахарын цөлийн өмнөд болон түүнээс урагш орших Африкийн гишүүн орнууд; (ii) болон (iii)-ын хувьд нийт саналын эрхтэй гишүүдийн дөрөвний гурваас доошгүйг төлөөлсөн Захирагч нарын гуравны хоёроос доошгүй саналаар хэрэгжүүлж болно. Үний дагуу энэхүү Хэлэлцээрт ба түүний хавсралтуудад “Төв ба Зүүн Европын орнууд”, “Төв ба Зүүн Европын орнууд”, “хүлээн авагч орон (буюу орнууд) гэж заасан аливаа заалт нь Монгол Улс болон Газрын дундад тэнгисийн Өмнөд болон Зүүн бүсийн орнууд, түүнчлэн Сахарын цөлийн өмнөд болон түүнээс урагш орших Африкийн орнуудад нэгэн адил хамаарна.

**12 дугаар зүйл**

### **ХЭВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ХЯЗГААРЛАЛТ**

- 1. Банкны санхүүгийн тогтвортой байдлыг хамгаалах зорилгоор хөрөнгийн зохистой харьцааны хэмжүүрүүдэд тохирох хязгаарлалтыг Захирлуудын зөвлөл тогтоон мөрднө.**



Annex 1

**Amendment to the Agreement Establishing the European Bank for Reconstruction and Development (“Agreement”) – Article 1**

Article 1 of the Agreement shall be amended to read as follows:

*“In contributing to economic progress and reconstruction, the purpose of the Bank shall be to foster the transition towards open market-oriented economies and to promote private and entrepreneurial initiative in the Central and Eastern European countries committed to and applying the principles of multiparty democracy, pluralism and market economics. Subject to the same conditions, the purpose of the Bank may also be carried out in (i) Mongolia; and in (ii) member countries of the Southern and Eastern Mediterranean; and (iii) a limited number of member countries of sub-Saharan Africa; in each case under (ii) and (iii) as determined by the Bank upon the affirmative vote of not less than two-thirds of the Governors, representing not less than three-fourths of the total voting power of the members. Accordingly, any reference in this Agreement and its annexes to “Central and Eastern European countries”, “countries from Central and Eastern Europe”, “recipient country (or countries)” or “recipient member country (or countries)” shall refer to Mongolia and each of such countries of the Southern and Eastern Mediterranean and sub-Saharan Africa as well.”*

The following understandings shall apply with respect to the amended Article 1 of the Agreement:

- a. The term “*sub-Saharan Africa*” as set out under Article 1 of the Agreement shall be understood to mean the Sub-Saharan Africa region as defined by the World Bank Group.
- b. The limitation on the number of member countries of sub-Saharan Africa in which the Bank may carry out its purpose as set out under Article 1 of the Agreement shall be understood so as to enable a limited and incremental expansion of the geographic scope of the Bank’s operations, in accordance with the measures and mechanisms set out in the report of Board of Directors “*Amendment of the Agreement Establishing the European Bank for Reconstruction and Development in order to enable the limited and incremental expansion of the geographic scope of the Bank’s operations to sub-Saharan Africa and Iraq*”. In this context, an affirmative vote of not less than three-fourths of the Governors, representing not less than four-fifths of the total voting power of the members shall be required to approve any further increment to the expansion.
- c. Iraq shall be incorporated into the Southern and Eastern Mediterranean region for the purposes of the Agreement, and consequently the term “*Southern and Eastern Mediterranean*” as set out under Article 1 of the Agreement shall be understood to mean the region consisting of the countries that have a shoreline on the Mediterranean as well as Jordan and Iraq, which are closely integrated into this region.

**Annex 2**

**Amendment to the Agreement Establishing the European Bank for Reconstruction and Development (“Agreement”) – Article 12.1**

Article 12.1 of the Agreement shall be amended by deleting its existing text and introducing a new text as follows:

*"1. The Board of Directors shall establish and maintain appropriate limits with respect to capital adequacy metrics, in order to protect the financial soundness and sustainability of the Bank."*

## ТАНИЛЦУУЛГА

2024 оны 10 дугаар  
сарын 23-ны өдөр

Улаанбаатар  
хот

Хэлэлцээрт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хүлээн  
зөвшөөрч, соёрхон батлах тухай хуулийн төслийн тухай

Европын сэргээн босголт, хөгжлийн банк үүсгэн байгуулах тухай хэлэлцээрт  
оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрч, соёрхон батлах тухай хуулийн төсөл,  
хуулийн төслийн үзэл баримтлалыг Монгол Улсын Олон улсын гэрээний тухай хууль,  
Хууль тогтоомжийн тухай хуульд нийцүүлэн, “Аргачлал батлах тухай” Засгийн газрын  
2016 оны 59 дүгээр тогтоолын дагуу боловсрууллаа.

- Хэлэлцээрт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрч, соёрхон батлах  
тухай хуулийн төсөл боловсруулах аргачлалын тайлан  
(хуудас 2)
- Хэлэлцээрт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрч, соёрхон батлах  
тухай хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан  
үнэлгээний тайлан  
(хуудас 3-12)
- Хэлэлцээрт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрч, соёрхон батлах  
тухай хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх ажлын тайлан  
(хуудас 13-16)
- Хэлэлцээрт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрч, соёрхон батлах  
тухай хуулийн төслийн зардлын тооцооны тайлан  
(хуудас 17)

Европын сэргээн босголт, хөгжлийн банк үүсгэн байгуулах тухай хэлэлцээрт  
оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрч, соёрхон батлах тухай хуулийн төсөл  
батлагдсанаар ЕСБХБ-ны санхүүжилтийн үйл ажиллагаа Төв болон Зүүн Европ,  
Өмнөд болон Зүүн Газар дундын тэнгисийн бус нутаг болон Монгол зэрэг орнуудыг  
хамарч байсныг өргөжүүлж Сахарын цөлөөс өмнөх Африкийн бус нутгийн орнуудад  
үйл ажиллагаагаа явуулах боломж бүрдэх тул хуулийн төслийн хэрэгцээ, шаардлага,  
үр нөлөөг үнэлэх, зардлын тооцоог төслийн үр дүнд тулгуурлан хийсэн болно.

**НЭГ. ЕВРОПЫН СЭРГЭЭН БОСГОЛТ, ХӨГЖЛИЙН БАНК ҮҮСГЭН  
БАЙГУУЛАХ ТУХАЙ ХЭЛЭЛЦЭЭРТ ОРУУЛСАН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙГ ХҮЛЭЭН  
ЗӨВШӨӨРЧ, СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ  
АРГАЧЛАЛЫН ТАЙЛАН**

Европын сэргээн босголт, хөгжлийн банк үүсгэн байгуулах тухай хэлэлцээрт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрч, соёрхон батлах тухай хуулийн төсөл (цаашид хуулийн төсөл гэх)-ийн үзэл баримтлалыг олон улсын санхүүгийн байгууллагуудын өмнө Монгол Улсын байр суурийг бататгаж, ил тод байдал, хөрөнгө оруулагчдад итгэл төрүүлж, хууль зүйн орчныг тогтвортой, найдвартай байлгах нөхцөлийг бүрдүүлэх үр дагаварт үнэлгээ хийсэн судалгааг үндэслэн боловсруулсан.

(Хүснэгт 1)

Хуулийн төслийн үзэл баримтлалд тусгах асуудал	Тусгасан Эсэх
Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага	Тийм
Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ	Тийм
Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, хүрэх үр дүн, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай санал	Тийм
Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуултай уялдсан байдал, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хуулийн талаарх санал	Тийм

Хуулийн төслийн үг хэллэг нь оновчтой, нийтээр нэг мөр ойлгож хэрэглэхэд хүндрэл үүсэхгүй, хэл зүй, найруулгад тавигдах шаардлагыг хангасан байхаар боловсруулсан бөгөөд дараах шаардлагад нийцүүлсэн болно.

(Хүснэгт 2)

Шаардлага	Нийцсэн байдал
Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх	Уялдсан.
Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгах	Тухайн хуулиар зохицуулагдах нийгмийн харилцаанд хамаарах асуудал байхгүй.
Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх	Тусгагдаагүй.
Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх	Тусгагдаагүй
Зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх	Хоёр зүйлтэй хуулийн төсөл тул хоорондоо зөрчилдөх зүйл, хэсэг, заалт байхгүй.
Хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх	Тусгагдаагүй

# **ХОЁР. ЕВРОПЫН СЭРГЭЭН БОСГОЛТ, ХӨГЖЛИЙН БАНК ҮҮСГЭН БАЙГУУЛАХ ТУХАЙ ХЭЛЭЛЦЭЭРТ ОРУУЛСАН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРЧ, СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН СУДАЛСАН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

## **1. Ерөнхий зүйл**

Монгол Улс нь 2000 оны 7 дугаар сарын 26-ны өдөр Европын сэргээн босголт, хөгжлийн банк (ЕСБХБ)-ыг үүсгэн байгуулах тухай хэлэлцээрийг хүлээн зөвшөөрч, Монгол Улсын Их Хурал соёрхон баталснаар тус банкны 61 дэх гишүүнээр элсэн орсон.

ЕСБХБ-ны Захирагч нарын зөвлөл 2023 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн 259 болон 260 дугаар тогтоолыг баталж, ЕСБХБ үүсгэн байгуулах тухай хэлэлцээрийн 1 дүгээр зүйл болон 12.1 дүгээр зүйлүүдэд өөрчлөлт оруулахаар шийдвэрлэсэн.

## **2. Урьдчилан тандан судлах ажлын үе шат**

Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын (цаашид Аргачлал гэх) 2-т заасан үе шат бүрээр Хуулийн төслийг тандан судлах ажлыг зохион байгууллаа.

## **3. Асуудалд дүн шинжилгээ хийсэн байдал**

Европын сэргээн босголт, хөгжлийн банк үүсгэн байгуулах хэлэлцээрт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрч, соёрхон батлуулах тухай Хуулийн төслийг боловсруулсан. Хуулийн төсөл нь Аргачлалын 1.3-т заасан хүрээнд хамаарахгүй тул урьдчилан тандан судлах ажиллагааг Аргачлалын 2.1-т заасан үе шатны дагуу хийж гүйцэтгэлээ.

Европын сэргээн босголт, хөгжлийн банк (ЕСБХБ) үүсгэн байгуулах тухай хэлэлцээрт оруулсан өөрчлөлтүүд нь ЕСБХБ-ны дотоод засаглал, үйл ажиллагааны хүрээнд төвлөрч байгаа учир Монгол Улсад сөрөг нөлөө үзүүлэхгүй бөгөөд харин тус банкны үйл ажиллагааг төрөлжүүлж, банкны тогтвортой байдал болон гишүүн орнуудад үзүүлэх дэмжлэгийг сайжруулна гэж үзэж байна. Түүнчлэн, хэлэлцээрт оруулсан өөрчлөлтүүд нь олон улсын санхүүгийн байгууллагуудын өмнө Монгол Улсын үүрэг хариуцлагыг бататгаж, ил тод байдал, хариуцлагын зарчмыг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулах бөгөөд энэ нь хөрөнгө оруулагчдад илүү итгэл төрүүлж, хууль зүйн орчныг тогтвортой, найдвартай байлгах нөхцөлийг бүрдүүлнэ.

## **4. Асуудлыг шийдвэрлэх зорилгыг тодорхойлсон байдал**

Аргачлалын 4-т заасны дагуу асуудлыг шийдвэрлэх зорилтыг дараах байдлаар тодорхойлж байна. Европын сэргээн босголт, хөгжлийн банк үүсгэн байгуулах тухай хэлэлцээрт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрч, соёрхон батлах тухай хуулийн төслийг боловсруулах шаардлагатай гэсэн зорилтын тодорхойлж байна.

## **5. Асуудлыг зохицуулах хувилбарууд, тэдгээрийн зэрэг, сөрөг талыг харьцуулсан байдал**

Монгол Улсын Олон улсын гэрээний тухай хуулийн “8 дугаар зүйл. Заавал соёрхон батлах олон улсын гэрээ”, “8.1.Улсын Их Хурал дараах олон улсын гэрээг заавал соёрхон батална.”, “8.1.3.Монгол Улсын хуульд зааснаас өөр журам тогтоож байгаа, эсхүл тухайн гэрээг байгуулснаар, нэгдсэнээр, эсхүл хэрэгжүүлснээр Монгол

Улсын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, эсхүл хууль шинээр батлах шаардлагатай олон улсын гэрээ;” гэж заасан тул Аргачлалын 5.4.3-т заасны дагуу хуулийн төсөл шууд боловсруулах хувилбарыг сонголоо.

## 6. Зохицуулалтын хувилбаруудын үр нөлөөг тандан судалсан байдал

### ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

(Хүснэгт 2)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1. Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж буй эсэх	1.1. Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх			
	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	-	-	Ялгаварлан гадуурхсан зохицуулалтыг тусгахгүй.
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	-	Үгүй	Ялгаварлан гадуурхсан зохицуулалтыг тусгахгүй.
	1.1.3.Энэ нь тодорхой бүлгийн эмзэг байдлыг дээрдүүлэхийн тулд авч буй түр тусгай арга хэмжээ мөн бол олон улсын болон үндэсний хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж буй эсэх	-	-	Олон улсын болон үндэсний хүний эрхийн хэм хэмжээг зөрчиж байгаа зохицуулалт байхгүй.
	1.2. Оролцоог хангах			
	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцож боломжийг бурдуулсэн эсэх	-	Үгүй	Тодорхой зорилтот бүлэгт чиглээгүй.
	1.2.2.Ялангуяа зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдж буй, эсхүл хөндөгдж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	-	-	Тодорхой зорилтот бүлэгт чиглээгүй.
	1.3. Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал хариуцлага			
	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	-	-	Ард иргэдийн амар амьдрах нөхцөл сайжрана.
	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, НҮБ-ын хүний эрхийн механизмаас тухайн асуудлаар өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	-	-	Уг зөвлөмжтэй зөрчилдөх агуулга байхгүй.
	1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	-	Үгүй	Хариуцлагатай холбоотой зохицуулалт тусгах шаардлагагүй.
2. Хүний эрхийг	2.1. Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах бол энэ нь	-	Үгүй	Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгахгүй.

хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	хууль ёсны зорилгод нийцсэн эсэх			
	2.2. Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	-	Үгүй	Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгахгүй.
3. Эрх агуулагч	3.1.Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	-	Үгүй	Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлох шаардлагагүй.
	3.2. Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	-	Үгүй	Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлох шаардлагагүй.
	3.3. Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалzan үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	-	Үгүй	Эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэн зохицуулалт агуулаагүй.
